



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

**“Амар байна уу-2026” арга хэмжээнд
оролцох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/01 дүгээр захирамж, “Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв” (НӨҮГ)-ын даргын 2026 оны А/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргээс 2026 оныг “Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих” жил болгон зарласантай холбогдуулан “Их наяд плаза” төвд сар шинийн баярыг угтан зохион байгуулах “Амар байна уу-2026” үзэсгэлэн худалдаанд 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр дүүргээ сурталчлах өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв (М.Өсөхдэлгэр), Соёлын ордон (Б.Алтанцоож)-д үүрэг болгосугай.

2. “Амар байна уу-2026” үзэсгэлэн худалдаанд оролцоход зарцуулагдах төсвийг хавсралтаар баталж, 5,547,400 (таван сая таван зуун дөчин долоон мянга дөрвөн зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




А.СҮХБОЛД

AJIL2026 он ажил/захирамж

1226010032

Багахангай дүүргийн Засаг даргын
2026 онысарын-ны өдрийн
.....дугаар захирамжийн хавсралт



“АМАР БАЙНА УУ-2025” АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

№	Дуучин	Нийт хоног	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Инфлюенсер	1	1	3,000,000	3,000,000
2	Аи-92 бензин	л	260	3,050	793,000
3	Дизель түлш	л	80	3,180	254,400
4	Хоол	ш	60	25,000	1,500,000
Нийт дүн					5,547,400